



**БОДЬ ДААТГАЛ**  
ЭРСДЭЛИЙГ ДАВАХ ХҮЧ

**ХУВЬЦАА  
ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН  
МАТЕРИАЛ**

**2025**

## АГУУЛГА

1. Компанийн тухай товч
2. 2024 оны онцлох үйл явдлууд
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай ТУЗ-ийн тогтоол
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар
5. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг
6. Бизнесийн байдал, үйл ажиллагааны тайлан
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх
8. Хувьцаа эзэмшигчдийн хурлаас гарах тогтоолын төслүүд
9. Саналын хуудасны загвар

**АЛСЫН ХАРАА:**

**Азид бүртгэлтэй ердийн болон амьдралын даатгалын компани болно.** 2030 он гэхэд Хонконгийн хөрөнгийн биржийн 2-р самбарт бүртгэлтэй, Азид өрсөлдөгч санхүүгийн цогц хамгаалалт үзүүлэгч компани болно.

**ЭРХЭМ ЗОРИЛГО:**

**Хамтын хүчээр ирээдүйг баталгаажуулна.**

Хамтын хүчээр санхүүгийн нөөц бүрдүүлж харилцагч бүр ирээдүйгээ төлөвлөхөд тусалж, түүнд учирч болох эрсдэлээс хамгаалах хүчирхэг санхүүгийн компани эрсдэлийн зөвлөх байх болно.

**ҮНЭТ ЗҮЙЛС:**

- |                        |  |
|------------------------|--|
| <b>Харилцагч эрхэм</b> | Харилцагчаа халамжлан сэтгэл хангалуун байлгахын төлөө нөөц боломжийг бүрэн ашиглана.                                  |
| <b>Мэргэжлийн байх</b> | Мэргэжлийн ёс зүйг эрхэмлэн, ур чадвараа дайчлан, олон улсын түвшинд ажиллана.   |
| <b>Ухаалаг ажиллах</b> | Шинийг санаачилж, бүтээмжтэй, багаар ажиллана.   |
| <b>Хамтын хөгжил</b>   | Урт хугацааны тогтвортой, хамтын хөгжлийг эрхэмлэнэ. Хариуцлага Бүх түвшинд нягт нямбай, хариулагатай, нээлттэй байна. |

# БОДЬ ДААТГАЛЫН ТУХАЙ

(КОМПАНИЙН ТОЙМ ТАНИЛЦУУЛГА)

## АЛСЫН ХАРАА:

Байгуулагдсан он: 1995  
Нийт хөрөнгө: 40.9 тэрбум төгрөг  
Нийт хураамж: 32.1 тэрбум төгрөг  
Цэвэр хураамж: 22.1 тэрбум төгрөг

Бренд бүтээгдэхүүн: АХА  
бүтээгдэхүүн, Эрхэм эрүүл мэндийн  
даатгал, гэнэтийн ослын даатгал

## ДАВУУ ТАЛУУД

### Үйл ажиллагааны давуу тал:

Цахим нөхөн төлбөр: Бүх нөхөн  
төлбөрийн материалыг цахимаар  
авч байна.

### Үр дүн:

Цахим нөхөн төлбөр: Бүх нөхөн  
төлбөрийн материалыг цахимаар  
авч байна.

## 21 АЙМАГ ДАХЬ САЛБАРЫН БАЙРШИЛ:



ХАМТРАН АЖИЛЛАДАГ ДАВХАР ДААТГАГЧИД, БРОКЕРУУД



LLOYD'S



CHUBB

hannover re

KOREAN RE



UIB



PICC



## 2024 ОНЫ ОНЦЛОХ ҮЙЛ ЯВДАЛ


1. Бодь Даатгалын үйлчилгээний цэгүүд цахимд шилжлээ  
Бодь Даатгал ХК энэ Оюу Толгой ХХК-ийн үндсэн ажилтнуудын эрүүл мэндийг даатгах байгууллагаар сонгогдож хамтран ажилласан жил байлаа.



2. Бодь даатгал Монголын Оюутны Сагсан Бөмбөгийн Холбоотой хамтран ажиллана. Бид “Даатгалтай оюутан” хөтөлбөрийн хүрээнд МОСБХ-той хамтран хэрэгжүүлж, лигийн тэмцээнд оролцогч нийт их дээд сургуулийн оюутан тамирчдыг “Гэнэтийн ослын даатгал”-д хамруулж байна.



3. Бодь Даатгал 2024 оны хагас жилийн “Компанийн засаглалын кодекс”-ийн хэрэгжилтийн үнэлгээгээр 90.27% авч, “засаглал сайн, эрсдэлгүй” гэж үнэлэгдлээ!
4. Монголын анхны дроны даатгал хийж, эрүүл мэндийн яаралтай тусламжийн үйлчилгээнд шинэ боломжуудыг нээсэн. 2024.10.01-нд Цус сэлбэлт судлалын төвөөс Монгол-Японы эмнэлгийн яаралтай тусламжийн тасагт донорын цусыг дроноор тээвэрлэн хоёр хүний амь аварсан явдал болсон билээ.



## 5. Вебсайт шинэчлэлт

6. ТУЗ-ийн 2025.02.14-ний өдрийн хурлаар компанийн хувьцаа эзэмшигчдэд нэгж хувьцаанд 5 төгрөгийн, нийт 1,141,377,290 төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд мөнгөн хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэлээ.



6. **Power BI** хөгжүүлэлт хийгдсэнээр дотоод үйл ажиллагааны шийдвэр гаргалтын оновчлолыг сайжруулсан.





6. **ODOOERP** системийн шинэчлэлтээр бусад системтэй интеграци хийж, ажилтан, төлөөлөгч, брокерууд хэрэглэгчийн эрхийн тохиргоогоор вэб сайтад байрлах бүтээгдэхүүн үйлчилгээг газар зүйн байршлаас үл хамааран хаанаас ч хийх боломжтой болсон.



## ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ, ЗАР, ДЭГ



### ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2025 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 25/08

Улаанбаатар хот

#### Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйл, 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 болон 65 дугаар зүйлийн 65.3 болон 65.4 дэх заалтууд, 67 дугаар зүйлийн 67.1 болон 67.5 дахь заалтууд, 71 дүгээр зүйлийн 71.1 болон 71.3 дахь заалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, “Бодь Даатгал” ХК-ийн Дүрмийн 7.1 болон 7.3 дахь заалтуудыг тус тус үндэслэн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 сарын 13-ны өдрийн хурлаас **ТОГТООХ НЬ:**

1. Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал /цаашид “Хурал” гэх/-ыг 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдөр 11:00 цагт “БиДиСЕК ҮЦЦ” ХК-ийн /Agm.bdsec.mn/ веб суурьтай аппликейшнийг ашиглан цахим хэлбэрээр хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2025 оны 03 сарын 14-ний өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Хөрөнгийн биржийн цахим хуудас, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр буюу өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио, телевизийн аль нэгээр болон компани, арилжаа эрхлэх байгууллагын цахим хуудсаар дамжуулан 2025 оны 03 сарын 18-ны өдөр нийтэд мэдээлж, уг зарыг 2025 оны 04 сарын 02-ны өдөр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Ногдол ашиг авах болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2025 оны 04 сарын 04-ний өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2025 оны 03 сарын 21-ний өдөрт багтаан үнэт цаасны брокер дилерийн компанид хүргүүлсүгэй.
6. Дараах нэр бүхий хүмүүсийг хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:  
Хурал зохион байгуулах комиссын дарга: Гүйцэтгэх захирал А.Энхжаргал,  
Гишүүд: Үйл ажиллагааны газрын захирал М.Мөнхбаатар, ТУЗ-н Нарийн бичгийн дарга Ө.Батчимэг, Үйл ажиллагаа хариуцсан ерөнхий менежер Ж.Наранцрэг, Бүтээгдэхүүн Хөгжлийн менежер Г.Билгүүн, Ахлах хуульч Х.Сарангоо, Хуульч Б.Анар-эрдэнэ, Хөрөнгө оруулалтын алба С.Долгоон
7. Хурлын зарын загвар, хэлэлцэх асуудлыг нэгдүгээр хавсралтаар баталсугай.
8. Хурлын дэгийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.

9. Хурлын танилцаж болох баримт бичгийн жагсаалтыг гуравдугаар хавсралтаар баталсугай.
10. Хурлын саналын хуудасны загварыг дөрөвдүгээр хавсралтаар баталсугай.
11. Хурлын материалыг 2025 оны 03 сарын 21-ний өдөр брокер, дилерийн компаниудад хүргүүлж, хувьцаа эзэмшигчдэд Хурлын материалтай ажлын өдрийн 10:00-17:00 цагийн хооронд ирж танилцах боломж бүрдүүлэхийг Гүйцэтгэх захирал болон Хурал зохион байгуулах комисст даалгасугай.
12. Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдэд саналаа урьдчилан өгөх боломжоор хангаж Компанийн өөрийн байранд, харилцдаг үнэт цаасны компаниар болон “БиДиСек” ҮЦК ХК-ийн Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө 27/1, төв байр хаягаар дамжуулан урьдчилсан саналын хуудсыг хүлээн авах ба саналын хуудсыг хүлээн авах сүүлийн хугацаа 2025 оны 04 дүгээр сарын 22-ны өдрийн 15:00 цаг байна.
13. Хурлын даргаар Бодь Даатгал ХК-ийн Гүйцэтгэх захирал А.Энхжаргалыг томилсугай.
14. Хурлын тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэй томилсугай. Үүнд: Тооллогын комиссын дарга: Ахлах хуульч А.Сарангоо, Гишүүд: Хуульч Б.Анар-эрдэнэ, Хөрөнгө оруулалтын алба С.Дөлгөөн нарыг ажиллуулахыг зөвшөөрсүгэй.
15. Хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны тухай хуульд заасан хугацаанд Монголын хөрөнгийн бирж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхийг Хурлын дарга, Хурал зохион байгуулах комиссын дарга А.Энхжаргалд даалгасугай.
16. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг хүргүүлэх, бүртгүүлэх ажлыг хийж гүйцэтгэхийг ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Ө.Батчимэгт даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.БИЛЭГТ



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар  
сарын 13-ны өдрийн № 25/01-р тогтоолын

"Хавсралт №1"



## “БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ЗАР

Компанийн нэр: “БОДЬ ДААТГАЛ” ХК

Хаяг: Бодь цамхаг, Жигжиджавын гудамж 3, Бага тойруу, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар 15160

Хурал хуралдах өдөр, цаг: 2025 оны 04 сарын 23-ны өдөр 11:00 цагт болно.

Хурал зохион байгуулах хэлбэр: “Би Ди Сек ҮЦК” ХК-ийн / agm.bdsec.mn / веб суурьтай аппликейшнийг ашиглан цахим хуудсаар хуралдана.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр:

2025 оны 04 сарын 04-ний өдөр

Хувьцаа эзэмшигчдийн хурлаар дараах асуудлуудыг хэлэлцэнэ. Үүнд:

1. 2024 оны санхүү, үйл ажиллагааны үр дүн танилцуулах
2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах
3. Ногдол ашгийн талаарх танилцуулга
4. 2025 оны санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах

Хувьцаа эзэмшигч та 2025 оны 04 сарын 22-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд өөрт тохиромжтой дараах газруудын аль нэгт эсхүл <https://bodi-insurance.com/> цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1
- “БОДЬ ДААТГАЛ” ХК-ийн байранд ирж хурал зохион байгуулах комиссын гишүүн Г.Билгүүнд мэдэгдэн хурлын баримт бичигтэй танилцах боломжтой.

Хуралд биечлэн оролцох боломжгүй хувьцаа эзэмшигчдийг санал өгөх боломжоор хангах зорилгоор 2025 оны 04 сарын 22-ны өдрийн 15:00 цаг хүртэл доорх сувгуудаар дамжуулан урьдчилсан саналын хуудсыг хүлээн авна. Үүнд:

- Өөрийн үйлчлүүлдэг үнэт цаасны компани
- “Бодь Даатгал” ХК-ийн өөрийн байр, Хаяг: Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, Жигжиджав гудамж 3, Бодь цамхаг 3 давхар
- “БиДиСЕК ҮЦК” ХК-ийн төв байр, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 8-р хороо, Залуучуудын өргөн чөлөө, 27/1

Холбоо барих: 75054800

И-мэйл хаяг: [info@bodi-insurance.com](mailto:info@bodi-insurance.com)

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Толовлон Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн № 25/01-р тогтоолын



**“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

Хурал 2025 оны 04 дүгээр сарын 23-ны өдрийн 11:00 цагт эхэлнэ.

	Хэлэлцэх асуудал	Хугацаа	Хариуцан танилцуулагч
1	Хурлын ирцийг бүртгэх	11:00-11:20	Тооллогын комисс
2	Хурлын ирцийг хурлын дарга болон хуралд оролцогч нарт мэдээлэх	11:20-11:30	Тооллогын комисс
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	11:30-11:35	Хурлын дарга
<b>Хурлаар хэлэлцэх асуудлууд</b>			
4	1. 2024 оны санхүү, үйл ажиллагааны үр дүн танилцуулах	11:35-11:50	Хурлын дарга А.Энхжаргал
	2. Компанийн 2024 оны санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг танилцуулах, батлах	11:50-12:00	ТУЗ-н дэргэдэх Аудитын хороо
	3. Ногдол ашгийн талаарх танилцуулга	12:00-12:05	Хурлын дарга А.Энхжаргал
	4. 2025 оны санхүү, үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулах	12:05-12:15	М.Мөнхбаатар
5	Хурлаас гарах шийдвэрийн төсөлтэй холбогдсон асуулт, хариулт	12:15-12:30	Хурлын дарга А.Энхжаргал
6	Саналын хуудас бөглөх заавар танилцуулах	12:30-12:40	Тооллогын комисс
7	Саналын хуудсаар санал авах	12:40-12:55	Тооллогын комисс
8	Хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн саналыг тоолж, нэгтгэх, боловсруулах	12:55-13:10	Тооллогын комисс
9	Тооллогын комисс санал хураалтын дүнг танилцуулах	13:10-13:20	Тооллогын комисс
10	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	13:20-13:25	Хурлын дарга А.Энхжаргал
11	Хурлыг хаах	13:25-13:30	Хурлын дарга А.Энхжаргал

Хурлын үргэлжлэх нийт хугацаа: 2 цаг 30мин

Шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болно.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар  
сарын 13-ны өдрийн № 25/01-р тогтоолын

"Хавсралт №3"



**“БОДЬ ДААТГАЛ” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН  
ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ  
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай Төлөөлөн удирдах зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн № 25/01 тоот тогтоол;
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зар;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
4. Компанийн 2024 оны үйл ажиллагааны тайлан;
5. Компанийн 2024 оны санхүүгийн тайлан;
6. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас гарах тогтоолын төсөл;
7. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх саналын хуудасны загвар.

Дээр дурдсан баримт бичиг нь 2025 оны 03 сарын 14-ний өдрийн дотор бэлэн болсон байна.

Компанийн тухай хуулийн 65.6-д заасан заалттай холбогдуулан хувьцаа эзэмшигч та бүхэнд танилцуулах зорилгоор дээрх материалуудыг компанийн албан ёсны цахим хуудас болох <https://bodi-insurance.com/> хаягт байршуулсан тул та бүхнийг эдгээр материалтай танилцахыг хүсэж байна.

**ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

## КОМПАНИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА, САНХҮҮГИЙН ҮР ДҮН

### БИЗНЕСИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2024 онд Монгол улсын эдийн засгийн бодит өсөлт 5.7 хувь, инфляцын түвшин 8.5 хувь гарсан бол даатгалын салбарын цэвэр хураамж 15,3 (3-р улирлын байдлаар) хувиар өссөн байна. Цэвэр хураамжийн өсөлтөд тээврийн хэрэгслийн даатгалын хураамж болон гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, хөрөнгө болон хариуцлагын даатгалын цэвэр хураамж өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

“Бодь Даатгал” ХК-ийн хувьд 2024 онд санхүүгийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай гарсан байна. Үүнд:

Нийт хураамжийн орлого 11,07 хувиар өсөж 32,1 тэрбум, цэвэр хураамжийн орлого 0,2 хувиар өсч 22.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Цэвэр хураамжийн орлогын 86 хувийг гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, тээврийн хэрэгсэл, хөрөнгө хариуцлагын даатгал бүрдүүлж байна.

Компани 2024 оны жилийн эцсээр даатгалын цэвэр хураамжийн төлөвлөгөө 91.5%-ийн гүйцэтгэлтэй гарсан ба орон нутгийн төлөвлөгөөний гүйцэтгэл 75%-тай гарсан нь нийт гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

Даатгалын төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтийн зохистой түвшин 130 % байхаас гүйцэтгэл 233%-тай гарсан нь 2-р түвшин буюу хангалттай үзүүлэлттэй гарчээ.

2024 оны байдлаар нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ 9.19 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 32.6 хувиар буюу 2.7 тэрбум төгрөгөөр өсгөж зохистой түвшинд байгуулж ажилласан байна.

Компанийн цэвэр хосолсон харьцаа 110.5% гарсан ба зардлын харьцаа, хохирлын харьцаа зохистой түвшинд байх ба хосолсон харьцаа зохист түвшнээс 5.5 хувиар давсан нь орлого тооцсон хураамж 2 тэрбумаар буурсан нь нөлөөлсөн байна.


Тайлант үеийн цэвэр ашиг 2.5 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 92.3%-иар өсөж хуримтлагдсан ашиг 44,1 % буюу 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь компани 2024 онд хангалттай сайн ажилласан гэж үзэж байна.

Цаашид даатгалын хосолсон харьцааг зохистой түвшинд барьж, андррейтингийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж даатгалын борлуулалтыг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг илүү өсгөж ажиллахад анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.




**ДААТГАЛЫН САЛБАРЫН ҮЗҮҮЛЭЛТ:**


**НИЙТ ХУРААМЖ**



**ЦЭВЭР ХУРААМЖ**




**НӨХӨН ТӨЛБӨР**




**ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ:**


**НИЙТ ХУРААМЖ**



**ЦЭВЭР ХУРААМЖ**




**НӨХӨН ТӨЛБӨР**




**ЗАХ ЗЭЭЛД ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ:**


**НИЙТ ХУРААМЖ**



**ЦЭВЭР ХУРААМЖ**



**НӨХӨН ТӨЛБӨР**



2024 онд 22.1 тэрбум төгрөгийн цэвэр хураамжийн орлогыг төвлөрүүлсэн ба жолоочийн хариуцлагын даатгал өмнөх оноос 34% буурсан. Энэ нь тус бүтээгдэхүүн хохирлын харьцаа өндөр байснаас шалтгаалан хумих бодлого, андеррайтингийн бодлого хэрэгжүүлсний үр дүн юм.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын хувьд 2022 оны 5.4 тэрбум байсан бөгөөд харин 2023 оны хувьд 3.6 тэрбум төгрөг хүртэл буурсан бол 2024 оны жилийн эцсийн байдлаар 1.8 тэрбум болж буурсан.

Энэ нь борлуулалтын багцад эзлэх хувийн жин буурсантай холбоотойгоор нийт нөхөн төлбөрийн дүн буурсан ч 2023 оны 9 дүгээр сар хүртэл хийгдсэн гэрээний үүргийн гүйцэтгэл хэрэгжиж, борлуулалттай харьцуулахад хохирлын харьцаанд өндөр нөлөөллийг бий болгосон. Орон нутгийн хувьд тус бүтээгдэхүүний хохирлын харьцаа 45 орчим хувьтай байдаг нь хохирлын харьцааг бууруулах гол хөшүүрэг болно гэж үзсэн ч Улаанбаатар хотод байгуулагдсан гэрээний тоо нөлөөлөл үзүүлсэн.

<b>Бүтээгдэхүүн</b>	<b>2023</b>	<b>2024</b>	<b>Өсөлт</b>
Жолоочийн хариуцлага	2,687.2	1,774.76	-34.0%
Тээврийн хэрэгсэл	4,964.6	5,481.33	10.4%
Эрүүл мэнд	8,671.5	8,079.20	-6.8%
Хөрөнгө	2,395.6	3,423.29	42.9%
Хариуцлага	2,046.4	2,672.74	30.6%
Мал амьтад	465.1	233.43	-49.8%
Бусад	836.8	485.31	-42.0%
<b>Нийт цэвэр хураамж</b>	<b>22,067.2</b>	<b>22,150.1</b>	<b>0.4%</b>


2024 онд нийт 11.2 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийн 21.5% буюу 2.4 тэрбум төгрөгийг давхар даатгагч, үлдсэн 8.8 тэрбум төгрөгийг компани өөрөө хариуцан төлсөн ба 91.1 сая төгрөгийг буруутай этгээдээс буцаан авсан. Компанийн 2024 оны хохирлын харьцаа өмнөх оноос 6.4%-иар буурч, 52.9%-д хүрсэн нь хосолсон харьцаанд голлох нөлөө үзүүлсэн.

Зардалд тооцсон нөхөн төлбөрийн дүн	2023	2024	Өсөлт
Гэнэтийн осол, эмчилгээний даатгал	5,283.26	4,291.70	-18.8%
Хөрөнгийн даатгал	389.81	881.80	126.2%
Авто тээврийн хэрэгслийн даатгал	1,474.37	1,489.44	1.0%
Мал амьтдын даатгал	303.86	275.47	-9.3%
Хариуцлагын даатгал	195.71	188.82	-3.5%
Жолоочийн хариуцлагын даатгал	3,681.56	1,532.01	-58.4%
Бусад	510.69	15.07	-97.1%
<b>Нийт</b>	<b>11,839.26</b>	<b>8,674.32</b>	<b>-26.7%</b>

Компани 2024 онд 15,728 нөхөн төлбөрийн материалыг хүлээн авч 11.1 тэрбум төгрөгийн нөхөн төлбөрийг шийдвэрлэсэн.


Үүнээс Жолоочийн хариуцлагын албан журмын даатгалын 1,162 тохиолдлын 1.5 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон нь өмнөх оны мөн үеэс тохиолдлын тоо 63 хувь, нөхөн төлбөрийн дүн 58.4 хувиар тус тус буурсан.

Мөн тээврийн хэрэгслийн андеррайтингийн бодлого болон гэрээнд өөрчлөлт оруулснаар нөхөн төлбөрийн 1,066 тохиолдлын 1.4 тэрбум төгрөгийн нөхөн төлбөр олгосон. Энэ нь өмнөх оны мөн үеэс тохиолдлын тоо 27.3 хувь нөхөн төлбөрийн дүн 0.42 тэрбум төгрөгөөр тус тус буурсан.



2024 оны жилийн эцсийн байдлаар 766 дуудлагыг Автосос ХХК-д шилжүүлсэн бөгөөд өмнөх оны өмнө үеэс 4.4 дахин буурсан байна. Энэхүү 2,634 дуудлагыг дундаж нэг дуудлагыг 25,000 төгрөгөөр тооцож үзвэл 65.8 сая төгрөг хэмнэсэн байна. Харин шилжүүлсэн дуудлагаас 17.5 хувь буюу 594 дуудлагыг даатгуулагч цуцалсан байна. Энэ нь жилийн эцсийн дундаж нөхөн төлбөр 860,699 төгрөгөөр тооцож үзвэл 513.8 сая төгрөгийн нөхөн төлбөр гарахаас сэргийлж чадсан байна.


Ослын дуудлага (сар)



## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

Орлогын үзүүлэлтүүд	2022	2023	2024	Өсөлт
Цэвэр хураамж	23,651	22,067	22,150	0.4%
Орлогод тооцсон хураамж	19,948	24,637	21,099	-14.4%
Цэвэр нөхөн төлбөр	12,142	11,839	8,674	-26.7%
Зардалд тооцсон нөхөн төлбөр	13,011	13,678	9,705	-29.0%
Гэрээний зардал	3,102	3,564	2,922	-18.0%
Үйл ажиллагааны зардал	8,592	8,187	10,352	26.4%
Давхар даатгалын орлого	2,349	1,237	1,828	47.8%
Хөрөнгө оруулалтын орлого	1,092	1,100	2,915	165.0%
Цэвэр ашиг	(1,365)	1,392	2,515	80.7%
Хохирлын харьцаа	61%	48%	53%	5%
Үйл ажиллагааны зардлын харьцаа	43%	34%	58%	24%
Гэрээний зардлын харьцаа	16%	14%	14%	0%
Хосолсон харьцаа	119%	96%	111%	15%

Балансын үзүүлэлтүүд	2022	2023	2024	Өсөлт
Мөнгөн хөрөнгө	15,654	18,937	23,191	22.5%
Даатгалын авлага	5,015	3,499	3,982	13.8%
Бусад хөрөнгө	11,000	10,232	13,754	34.4%
Нийт хөрөнгө	31,669	32,671	40,927	25.3%
Өр төлбөр	5,120	646	2,507	288.1%
Бусад өр төлбөр	3,220	1,894	1,881	-0.7%
Нөөц сан	8,435	19,070	23,809	24.9%
Эздийн өмч	9,194	11,060	12,730	15.1%
Нийт эздийн өмч, өр төлбөр	25,969	32,671	40,927	25.3%
Төлбөрийн чадвар	109%	2-р түвшин	2-р түвшин	-




Багц бүрдүүлэлтийн төлөвлөгөөг макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн төлөв байдал болон хөрөнгө оруулалтын боломжууд дээр үндэслэн эрсдэл багатай, хөрвөх чадвар өндөртэй хөрөнгөнд хөрөнгө оруулалт хийдэг.

Үзүүлэлт сая төгрөг	2023 он	2024 он	Өсөлт
Хөрөнгө оруулалт	18,690,510	22,442,334	20.1%
Хөрөнгө оруулалтын орлого	1,100	2,915	164.8%
Өгөөжийн хувь	7.4%	11.2%	3.8%


Компанийн мөнгөн хөрөнгө болон хөрөнгө оруулалтын үлдэгдлийг 2022 оны 12 сарын 31-ны өдрөөр харвал дараах байдалтай байна.

Үзүүлэлт сая төгрөг	2023 он	2024 он	Өсөлт
Хадгаламж	11,946,020	19,935,933	66.9%
Бонд	4,871,868	980,000	-79.9%
Хувьцаа	1,289,422	1,096,894	-14.9%
Хөрөнгө оруулалт	400,000	400,000	0%
Нийт	18,607,310	22,412,827	21.6%

### ХОСОЛСОН ХАРЬЦАА




### ЗАРДЛЫН ХАРЬЦАА



2020 оны 5 сард Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан IPO хийж, олон нийтэд компанийн нийт хувьцааны 15%-ийг санал болгон нийт 5.3 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг амжилттай татан төвлөрүүлж, олон нийтэд нээлттэй компани болсон.

2024 оны 12-р сарын 31-ний хаалтын ханш 88.81 төгрөг



2024 оны татварын дараах цэвэр ашгаас 1,141,377,290 төгрөгийг ногдол ашиг, нэгж хувьцаанд ногдох хэмжээ 5 төгрөг





**ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ  
ХУРЛААС ГАРАХ ТОГТООЛЫН ТӨСЛҮҮД**



## БОДЬ ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 04 сарын 23-ны өдөр

№ 25/01

Улаанбаатар хот

Компанийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсгийг удирдлага болгон Бодь даатгал ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг хэлэлцсэний үндсэн дээр 2025 оны 04 сарын 23-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын Тооллогын комиссын ..... тоот тогтоолыг тус тус дүнг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. Бодь даатгал ХК-ийн 2024 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг Хавсралт №1-т заасны дагуу баталсугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН

ХУРЛЫН ДАРГА

А.ЭНХЖАРГАЛ

## 2024 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЛААРХ ДҮГНЭЛТ

### Бодь Даатгал ХК-ийн Хувьцаа эзэмшигчдэд:

2024 онд Монгол улсын эдийн засгийн бодит өсөлт 5,7 хувь, инфляцын түвшин 8,5 хувь гарсан бол даатгалын салбарын цэвэр хураамж 15,3 (3-р улирлын байдлаар) хувиар өссөн байна. Цэвэр хураамжийн өсөлтөд тээврийн хэрэгслийн даатгалын хураамж болон гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, хөрөнгө болон хариуцлагын даатгалын цэвэр хураамж өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна.

“Бодь Даатгал” ХК-ийн хувьд 2024 онд санхүүгийн гол үзүүлэлтүүд дараах байдалтай гарсан байна. Үүнд:

### Хураамжийн орлого

Нийт хураамжийн орлого 11,07 хувиар өсөж 32,1 тэрбум, цэвэр хураамжийн орлого 0,2 хувиар өсч 22.1 тэрбум төгрөгт хүрсэн байна. Цэвэр хураамжийн орлогын 86 хувийг гэнэтийн осол эмчилгээний зардлын даатгал, тээврийн хэрэгсэл, хөрөнгө хариуцлагын даатгал бүрдүүлж байна.

Компани 2024 оны жилийн эцсээр даатгалын цэвэр хураамжийн төлөвлөгөө 91.5%-ийн гүйцэтгэлтэй гарсан ба орон нутгийн төлөвлөгөөний гүйцэтгэл 75%-тай гарсан нь нийт гүйцэтгэлд нөлөөлсөн байна.

### Төлбөрийн чадварын үзүүлэлт

Даатгалын төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлтийн зохистой түвшин 130 % байхаас гүйцэтгэл 233 %-тай гарсан нь 2-р түвшин буюу хангалттай үзүүлэлттэй гарчээ.

### Нөөцийн сан

2024 оны байдлаар нөхөн төлбөрийн нөөц сангийн хэмжээ 9,19 тэрбум төгрөг байгаа нь өмнөх онтой харьцуулахад 32.6 хувиар буюу 2.7 тэрбум төгрөгөөр өсгөж зохистой түвшинд байгуулж ажилласан байна.

Компанийн цэвэр хосолсон харьцаа 110.5% гарсан ба зардлын харьцаа, хохирлын харьцаа зохистой түвшинд байх ба хосолсон харьцаа зохист түвшнээс 5,5 хувиар давсан нь орлого тооцсон хураамж 2 тэрбумаар буурсан нь нөлөөлсөн байна.

## Ашигт ажиллагаа

Тайлант үеийн цэвэр ашиг 2.5 тэрбум төгрөг буюу өмнөх оноос 92.3%-иар өсөж хуримтлагдсан ашиг 44,1% буюу 1.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь компани 2024 онд хангалттай сайн ажилласан гэж үзэж байна.

Цаашид даатгалын хосолсон харьцааг зохистой түвшинд барьж, андррейтингийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулж даатгалын борлуулалтыг нэмэгдүүлэх, ашигт ажиллагааг илүү өсгөж ажиллахад анхаарч ажиллах нь зүйтэй гэж үзэж байна.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.БИЛЭГТ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2025 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн № 25/01-р тогтоолын



**“БОДЬ ДААТГАЛ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛААР ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭЭС САНАЛ АВАХ ХУУДАС**

Хувьцаа эзэмшигчийн овог .....нэр.....

Регистрийн дугаар .....

Эзэмшиж буй энгийн хувьцааны тоо: .....

Бүртгэсэн / Үнэт цаасны компани / .....

Брокерын овог: ..... нэр: .....

*“БОДЬ ДААТГАЛ” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2025 оны 04 дүгээр сарын 21-ний өдрийн 11.00 цагт цахимаар зохион байгуулагдана.*

**Дараах хэлэлцэх асуудлуудад ЕРДИЙН АРГААР санал хураана.**

**Саналын хуудас бөглөх заавар:** Ердийн журмаар саналаа өгөхөд асуудал бүрээр “зөвшөөрсөн”, “татгалзсан”, “түдгэлзсэн” аль нь болохыг ✓ тэмдэглэж санал болгоны ард гарын үсгээ зурна.

№	Хэлэлцэж, батлах асуудлууд	Хурлаас гарах шийдвэрийн төсөл	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн	Татгалзсан тохиолдолд таны өгөх санал	Гарын үсэг
1.	Компанийн 2024 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-н дүгнэлтийг хэлэлцэн батлах	Тогтоол №	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>		

**Хувьцаа эзэмшигчийн бөглөх хэсэг**

Хувьцаа эзэмшигч хувь хүний бөглөх хэсэг	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн бөглөх хэсэг
Хувьцаа эзэмшигч иргэний овог, нэр .....	Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийн нэр .....
Гарын үсэг.....	Улсын бүртгэлийн дугаар.....

Хэрэв иргэн та саналаа итгэмжлэгдсэн  
этгээдээр төлөөлүүлэх бол итгэмжлэгдсэн  
төлөөлөгчийн мэдээллийг дор бичин  
итгэмжлэлийн хамт саналын хуудсыг ирүүлнэ  
ҮҮ.

Итгэмжлэгдсэн төлөөлөгчийн овог, нэр:

Регистрийн дугаар:

Саналын хуудсыг хүлээлгэн өгсөн огноо, цаг: .....

Саналын хуудсыг хүлээн авсан этгээдийн нэр, гарын үсэг:.....

Хувьцаа эзэмшигч хуулийн этгээдийг  
төлөөлж хуралд оролцсон итгэмжлэгдсэн

төлөөлөгчийн нэр:

Албан тушаал:.....

Гарын үсэг: .....

*Тооллогын комиссын бөглөх хэсэг:*

Саналын хуудсыг хүчинтэй/хүчингүйд (доогуур зурах) тооцон тоолсон

Тооллогын комиссын Дарга: /...../

Гишүүн: .....

Гишүүн: .....

Гишүүн: .....

Гишүүн: .....

Хүчингүйд тооцсон бол шалтгаан .....

.....

.....

### САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцох боломжгүй тохиолдолд харилцагч брокерын компаниараа дамжуулан хурлын материалтай танилцан саналын хуудсаа өгөх боломжтой.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. **Ердийн аргаар** өгөх санал хураалтад хэлэлцэх асуудал тус бүр дээр нэгээс олон тэмдэглэгээ хийсэн тохиолдолд санал хүчингүйд тооцогдоно.
4. Гарын үсгээ зураагүй санал хүчингүйд тооцогдоно.
5. Итгэмжлэлээр санал өгч буй итгэмжлэгдсэн төлөөлөгч нь итгэмжлэл дээрх өөрийн баталгаат гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
6. Насанд хүрээгүй хувьцаа эзэмшигчийн асран хамгаалагч нь хүүхдийнхээ бус өөрийнхөө гарын үсгийг зурснаар санал хүчинтэйд тооцогдоно.
7. **Гарын үсэггүй санал хүчингүйд тооцогдоно.**

